



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.31 № 01/640
танай -ны № -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ
СҮМЫН АРДЧИЛСАН НАМЫН
ХОРООНЫ ДАРГА Б.БАТТУВШИН
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Ханх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Ханх сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Ханх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Ханх сумын Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Ханх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцоо

ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Ханх сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (6 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Ханх сумын Ардчилсан намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Ханх сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай,

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**ХАНХ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНЫ ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго

1. Төр иргэний хамтын ажиллагаанд сууриссан, байгаль орчинд ээлтэй, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын хөгжилд тулгуурлаж хүний амьдрах, ажиллах, хөгжих таатай орчныг бүрдүүлсэн, хүнд суртал авлигаас ангид, ил тод нээлттэй, хариуцлагатай сум болно.
2. Бүтээн байгуулалт бүр миний төлөө гэсэн хандлагыг иргэн бурд төлөвшүүлж иргэдийн оролцоотой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллана.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх зарчим

1. Төрийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй байна
2. Хэрэгжих үйл ажиллагаа бүр нь шударга эрх тэгш байдлыг хангасан байна
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч бүр өөрийн нөөц бололцоо, мэдлэг чадвараа бүрэн дайчлан хариуцлагатай ажиллана.
4. Ажил хариуцагч бүр шинийг эрэн хайж, өөрчлөлт шинэчлэлтийг хийж ажиллана.

Нэг. Нийгмийн салбарын бодлого

1.1 Эрүүл мэндийн бодлого:

Эрүүл мэндийн шинэчлэл-иргэн бүрд

Эрүүл мэндийн төвийн үйлчилгээг хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлж өвчлөл эндэгдлийг туштай бууруулан үйлчлүүлэгчээ дээдэлсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ

1.1 Эрүүл мэндийн бодлогын зорилтууд

- 1.1.1. Эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг бууруулж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах.
- 1.1.2. НЭМ-ийн асуудлыг сайжруулж, иргэдийн эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах, зөв зан үйлийг төлөвшүүлэн эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлэн иргэд хамт олны оролцоог нэмэгдүүлэх.
- 1.1.3. Эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах эх нялхсын эндэгдлийг гаргахгүй байх талаар тогтолцоог боловсронгуй болгож бүхий л үйл ажиллагаагаа хүүхдэд ээлтэй сум болгоход чиглүүлэх
- 1.1.4. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх чийрэгжүүлэх төвүүдийг дэмжиж, бүх нийтийн тамирын хөдөлгөөн өрнүүлэн ажиллана.
- 1.1.5. Сумын төвөөс алслагдсан эх, хүүхэд, эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.
- 1.1.6. Эрүүл мэндийн төвтэй хамтран жил бүр “Цэвэр цэмцгэр 00 бидний эрүүл мэнд” аяныг зарлаж үр дүнг тухай бурд нь тооцож ажиллана.

1.2 БОЛОВСРОЛ, ХҮҮХЭД ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хөгжилд дагуулсан багш - хүүхдэд ээлтэй сум

Хүүхэд бурийг хөгжих боломжоор адил тэгш хангаж сургууль завсардалтыг бүрэн халсан, хөгжсөн багш- үр дүнтэй сургалттай, эрүүл аюулгүй орчинтой олон нийтийн оролцоог хангасан хүүхдэд ээлтэй боловсролыг хөгжүүлнэ.
605

000000061

1.2.1. Хүүхдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх, төрлөх нутаг, түүх соёл уламжлалаа хайрлах хүмүүжлийг олгох тусгай төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

1.2.2. Сумын ЕБС-ийн гаднах талбай, биеийн тамирын задгай талбайг тохижуулна.

1.2.3. Албан бус боловсролыг дэмжин амьдрах ухааныг сургалтын чанарыг сайжруулж, түүнийг түшиглэн эмзэг бүлгийн иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран зохион байгуулна.

1.2.4. Хүүхдийн дуу хоолой, тулгамдаж буй асуудал, санал хүсэлтийг сонсох Хүүхдийн индэр ажиллуулах.

1.3 СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

Соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, идэвхтэй хөдөлгөөн эрүүл зан үйлийг төлөвшүүлнэ.

- 1.3.1 Сумын хэмжээний биет болон биет бус соёлын өвийн талаарх бүрэн хэмжээний судалгааны архивтай болно.
- 1.3.2 Нийтийн бие тамир, чийрэгжүүлэлтийн ажлын үр дүнг сайжруулан, хамрах хүрээг өргөжүүлж иргэдэд хүртээмжтэй, стандартад нийцсэн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн байр талбай, орчныг нэмэгдүүлж ашиглалтыг сайжруулна. /Спорт зал/
- 1.3.3 Төрийн албан хаагчдад ажлын байрны дасгал хөдөлгөөнийг зааж сурган хийлгэж хэвшилнэ.
- 1.3.4 Ардын авьяастан болон гоц авьяастай хүүхэд залуучуудыг бодлогоор дэмжин ажиллана.
- 1.3.5 Хүүхэд залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх хөл бөмбөгийн талбайтай болно.
- 1.3.6 Бүх нийтийг хамарсан Урлаг спортыг бага наадмыг зохион байгуулж хэвших.
- 1.3.7 Үндэсний спортыг хөгжүүлэх Морь, Бөх, Сурын холбоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх шагай харваа, мөсөн шагайн харваа төсөл хөтөлбөрт хамруулж, Цана тэшүүрийн спортыг бодлогоор дэмжиж хөгжүүлнэ.
- 1.3.8 Аялал жуулчлалын улирлыг уртасгах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн Ханх нутгийн онцлогийг харуулсан аяллын үйлчилгээг бий болгосон төсөл хөтөлбөрийг дэмжинэ.
- 1.3.9 Ханх суманд гадаадын жуулчин, дотоодын аялагчдад зориулсан мэдээллийн төвийг Бoomt болон төв гудамжинд бий болгоно.
- 1.3.10 Гар урлалын худалдаа, бусад үйлчилгээг цогцоор нь үзүүлэх "Жуулчны гудамж" бий болгоно.
- 1.3.11 Орон нутгийн иргэдэд мэргэжлийн байгууллагатай хамтран аялал жуулчлалын талаар мэдээлэл сургалт сурталчилгаа зохион байгуулна.
- 1.3.12 Ханх суманд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулсан Аялал жуулчлалын зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулж аялал жуулчлалын хөгжил тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх төрийн бодлогод тусгуулах ажлыг зохион байгуулна.
- 1.3.13 Аялал жуулчлал эрхлэх хүсэлтэй орон нутгийн иргэдийг бодлогоор дэмжиж төсөл хөтөлбөрт хамруулна.

1720090061 20200605

0000000062

- 1.3.14 Аялал жуулчлалын маршрутыг гаргаж, орон нутгийн иргэдийг отгийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

1.3.15 Өвлийн аялал жуулчлал хөгжүүлэх зорилгоор Аялал жуулчлалын компаниудтай хамтран “Далай ээжийн өвөл” эвент арга хэмжээтэй болно.

1.4 НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГО

“Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэг, иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллана”

- 1.4.1. Баг бүрийн зорилтот бүлгийг тодорхойлж тэдэнд чиглэсэн түлшний үнийн хөнгөлөлт, асаргаа сувилал, эм тариа, ихэр хүүхдүүд, байгалийн болон гэнэтийн осол протез, ортопедийн үйлчилгээнд иргэдийг хуулийн дагуу бүрэн хамруулж ажиллана.
 - 1.4.2. Өрхийн амьжиргааны түвшнийг үнэлэх судалгааг хийж, дэмжих шаардлагатай өрхийг тодорхой болгон нийгмийн халамжийн бодлогыг зорилтод бүлэгт чиглүүлэн ажиллана.
 - 1.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, тэдний нийгэм дэх үүрэг оролцоог сайжруулах, хөдөлмөр эрхлэх, сурч хүмүүжих боломжийг бурдуулна.

1.5 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО АЖИЛТАЙ ИРГЭН - ОРЛОГОТОЙ АРУУ

“Өрх, гэр бүлд чиглэсэн бодлого хэрэгжүүлж өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж ажилзнаа”

- 1.5.1. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг нэмэгдүүлж зээлийн хүртээмжийг сайжруулснаар өрхийн аж ахуй эрхлэх, хоршоо нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
 - 1.5.2. Сумын удирдлагууд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг жилд нэг удаа хүлээн авч уулзаж тэдний санал хүсэлтийг сонсож ажиллана.
 - 1.5.3. Иргэдэд ахуй үйлчилгээ үзүүлэх жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх, ажлын байруудыг шинээр гаргах зорилгоор “Ахуйн үйлчилгээний төв” барина.

ХОЁР. ТӨСӨВ САНХҮҮГИЙН БОДЛОГО ИРГЭДИЙН ОРЛЦООТОЙ -тэсвийн шинэчлэл

- 2.1.1. Төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийн төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор хэлэлцэн баталж төсвийн зарцуулалтыг бүх шатны байгууллагууд иргэдэд мэдээлэх тайлагнах “Шилэн дансны” хуулийг хэрэгжүүлж ажиллана.
 - 2.1.2. Төсвийн шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлж төсвийн захиран зарцуулалтын хариуцлагыг өндөржүүлнэ.
 - 2.1.3. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж татварын шинэчлэлийг сумандаа хэрэгжүүлж бизнесийн таатай орчин бурдуулна.
 - 2.1.4. Орон нутгийн хөгжлийн санд иргэдийн саналыг тусгах оновчтой системийг бий болгож төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулна.

**ГУРАВ: ДЭД БҮТЭЦ, ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТУУД.
ОНОВЧТОЙ ШИЙДЭЛ - ШИНЭ СҮМ**

“Шинэ дэвшилтэй техник технологид тулгуурласан эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор дэд бүтцийг хөгжүүлна”

- ### 3.1.1. Гудамж талбайн гэрэлтүүлгийг шинэчлэн намсгаадуулж ур засигтай

- гэрлэн чимэглэл бий болгож, “Чийдэнтэй турт” төслийг хэрэгжүүлнэ.

3.1.2. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу боловсруулж газрын бүртгэл тооллогыг зохион байгуулан газрын нэгдсэн сантай болж, газар зохион байгуулалт, газар олголтыг нэгдсэн тогтолцоонд оруулна.

3.1.3. Айл өрхийн хаягжилтиг шинэчлэн, нэгдсэн тэмдэг, тэмдэглэгээтэй болгож гудамж айл өрхийг хаягтай болгоно.

3.1.4 “Гудамж” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.2 ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО ОРОН НУТГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ - ЭРҮҮП АЮУЛГҮЙ ХҮНС

“Орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжин иргэдийг эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах стандартыг мөрдөж хэвшигүүлна”

- 3.2.1 Хүнсний хангамж, чанар, аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийг ойрын болон хэтийн хөгжлийн зорилтуудтай уялдуулан ажиллана.

3.2.2 Нийтийн хоолны үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг дэмжинэ.

3.2.3 Орон нутгийн брэнд бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх, урамшуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

3.2.4 “Нэг баг - Нэг бүтээгдэхүүн” төслийг хэрэгжүүлж үр дүнд хургэж Ханх сумын брэнд бүтээгдэхүүнуудийг дэмжих ажиллана.

ДӨРӨВ: БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО, БОДЛОГЫН ЗОРИЛТУУД

4.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЛОГО

“Байгалия хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар “ЭКО ХАНХ” болгон хөгжүүлж эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангана”

- 4.1.1 Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг илрүүлэн мэдээлж, шийдвэрлүүлж орчноо цэцэрлэгжүүлж ногоон орчин бүрдүүлсэн иргэн ААН байгууллагыг урамшуулах журам гаргана.
 - 4.1.2 Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах тээвэрлэх, дахин боловсруулах, "Хог хаягдлын менежментийг сайжруулах" төсөлт хэрэгжүүлнэ.
 - 4.1.3 Сумын айл өрхийн хог хаягдлыг нэгдсэн журмаар савлагаатай болгож, хашаанаас ачдаг байхаар шинэчлэл хийж, гудамжинд ил задгай хог асгаж хаяхыг бүрэн зогсоноо.
 - 4.1.4 Хог бохирын цэгийн менежментийг сайжруулна.
 - 4.1.5 Нуурын усыг бохирдлоос хамгаалах зорилгоор эрэг орчмын болон нууран доторх хотыг сар болгон цэвэрлэж байхаар бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж хэвшүүлэх. Рашиан ус, булаг шандын эхийг ханиж хамгаална.

ТАВ: ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГО, БОДЛОГЫН ЗОРИЛТУУД

5.1. ИРГЭНИЙ НИЙГЭМ, ТӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГЫН ЗОРИЛТУУД ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛ - ИРГЭНИЙ ОРОЛЦОО

“Төрийн үйл ажиллагааг иргэддээ ил тод, нээлттэй болгож, хариуцлага, хяналтыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон мөрдүүлж, хүнд суртал авлигаас ангид төрийн үйлчилгээг бий болгон чанар хүртээмжийг дэвшүүлнэ”

- 5.1.1 Төрийн үйлчилгээнд нийтийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг тэргүүн

ээлжид хангахыг эрхэмлэж, аливаа шийдвэр гаргахдаа иргэдийн "шууд оролцоо"- г хангана.

- 5.1.2 Төрийн байгууллагын үйл ажиллагааг авлигаас ангид ил тод нээлттэй болгож, иргэдэд тэгш шударгаар үйлчилдэг, итгэл дэмжлэгийг хүлээсэн төрийн хариуцлагатай тогтолцоог бүрдүүлнэ.
- 5.1.3 Төрийн байгууллага албан хаагчийн хууль зөрчсөн ёс зүйгүй үйлдэл нэг бүрд тодорхой хариуцлага тооцож байна.
- 5.1.4 Нэг цонхны үйлчилгээг сайжруулан угтан үйлчлэх үйлчилгээ болгож төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх болно.
- 5.1.5 Ханх сумын "Нээлттэй веб сайт" - аар иргэдийг бүх төрлийн мэдээллээр хангадаг болгоно.
- 5.1.6 Иргэдийн өргөдөл гомдлын бүртгэл хяналтыг сайжруулж, бичиг хэргийн программыг суурилуулж мэдээллийн баазтай болох, архивын цахим хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.1.7 Өрхийн бүртгэлийн судалгааг шинэчилж мэдээллийн баазтай болно.
- 5.1.8 Залуу малчдын зөвлөгөөнийг сумандаа зохион байгуулна.
- 5.1.9 Сумын төвийн айл өрхийг 10-тын системд оруулж 10-т тус бүрийг төрийн /үйлчилгээ/ албан хаагчид хариуцуулна.

5.2 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭРЭГЖИЛТ, ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ, ХИЛ ХАМГААЛАХ БОДЛОГЫН ЗОРИЛТУУД АЮУЛГҮЙ ОРЧИН ХАНХ СУМ

"Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, ил тод байдлыг бий болгосон хүний эрхийг дээдэлсэн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ"

- 5.2.1 Иргэдийн амар тайван ажиллаж амьдрах, сурч боловсрох орчныг бий болгож, нийгмийн хэв журмыг сахих, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн бүх байгууллага, иргэд бүрийн оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллана.
- 5.2.2 Ханх сумын гудамжнуудыг камертай болгоно. Архидан согтуурахын эсрэг арга хэмжээг чангатган иргэд, иргэний нийгмийн байгууллагын санал санаачилгыг дэмжин ажиллана.
- 5.2.3 Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй хийх тэмцлийг эрчимжүүлж, төрийн албаны үйл ажиллагааг иргэдэд хүнд сурталгүй, ил тод, алагчлалгүй, шударга, хүртээмжтэй болгоно. Хил хамгаалах туслах хүчний үйл ажиллагааг хилийн болон хил орчмын дэглэм сахиулах, хилчдэд туслахад чиглүүлж, удирдлагаар хангаж ажиллана.
- 5.2.4 Хүүхэд өсвөр үеийнхэнд Монгол эх орноороо бахархах, хилчин цэрэг эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлж, хилийн албаны үйл ажиллагааг сурталчлах зорилгоор ЕБС-д "Хилчний алдар" сургалт мэдээллийн танхим бий болгоно.

5.3 ГАДААД, ДОТООД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж үйл ажиллагаа нь үр өгөөжтэй нэгдмэл байх зарчмыг хэрэгжүүлж ажиллана'

- 5.3.1 ОХУ-ын хил залгаа орших Эрхүү муж, Буриад улсын муж хотуудтай сайн хөршийн уламжлалт харилцаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж хамтран ажиллах нөхцөлийг бүрэлдүүлж. эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг өргөжүүлнэ
- 5.3.2 ОХУ-ын хил гаалийн байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулан

6063000065

харилцан итгэлцлийг нэмэгдүүлж Монды-Туртын харилцааг иргэдийн эрх ашигт нийцүүлэхэд анхаарч ажиллана

- 5.3.3 Гадаад харилцааг аялал жуулчлалын бодлоготой нягт уялдуулан хилийн гарцыг боомт болгоход бүх талаар дэмжих хамтран ажиллана

5.3.4 Уламжлалт 'Эв модны наадам"-ыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж хүрээг өргөжүүлнэ

5.3.5 Хилийн зөрчил, хил дамнасан малын хулгайн асуудлаар хуулийн хүрээнд хамтран ажиллана.

2024 OH

Omy

60030000.6